

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ-Т ЗАРЛАЖ
БУЙ ПРОГРАММ ХАНГАМЖ, БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН САН
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТНИЙ АЖЛЫН БАЙРНЫ СОНГОН
ШАЛГАРУУЛАЛТАД УРЬЖ БАЙНА.**

АЖЛЫН БАЙР: Программ хангамж, бүртгэл, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн

АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ:

- Байгууллагын вэб сайт, IP эрх, ERP систем, цаг бүртгэлийн систем, дотоод мессенжер зэрэг программ хангамжийн боловсруулалт, ашиглалт, хамгаалалтыг хариуцах,
- Албан хаагчдын техник хэрэгслийн найдвартай ажиллагааг хангаж, сайжруулалт хийх,
- Сервер компьютерын мэдээллийн аюулгүй байдлыг хангах,
- Байгууллагын сурталчилгааны материалын эх бэлтгэл, хэвлэлийг мэргэжлийн түвшинд гүйцэтгэх,
- Паркийн нэгжүүдтэй холбоотой бүх төрлийн мэдээллийн санг бүрдүүлж, мэдээллийн сангийн нууцлал, аюулгүй байдал, найдвартай ажиллагааг хангах,
- Цахим архивын бүрдүүлэлт, хамгаалалт, нууцлалыг хариуцах

Байршил: Улаанбаатар хот, Багануур дүүрэг

Салбар: Үйлдвэрлэл, технологийн парк

Түвшин: Дунд шатны удирдлага

Төрөл: Бүтэн цагийн

Цалин: 700 000₮

ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

- Магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуулийг Мэдээллийн технологи, Программ хангамж, Техник хангамж, Мэдээллийн сүлжээний мэргэжлээр Бакалавр буюу түүнээс дээш зэрэгтэй төгссөн байх
- Программ хангамж хөгжүүлж, сүлжээ суурилуулж, тохиргоо хийж байсан туршлагатай байх
- Мэргэжлээрээ 3 болон түүнээс дээш жил ажилласан байх
- Гадаад хэлний зохих түвшний мэдлэгтэй байх
- Өөрийгөө илэрхийлэх болон харилцааны соёлтой байх
- Үнэнч шударга, ажилдаа хариуцлагатай ханддаг байх
- Цаашид тогтвор суурьшилтай ажиллах

ТАВИГДАХ ШААРДЛАГА

- Эх бэлтгэлийн программыг эзэмшсэн байх
- Эерэг зөв хандлагатай байх
- Багаар ажиллах чадвартай байх

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН БҮРТГЭЛ

Зарлагдаж буй сул орон тоонд тухайн албан тушаалд тавигдах боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадвар болон тусгай шаардлагыг хангасан, энэ албан тушаалд тогтвортой ажиллахыг хүссэн иргэнийг бүртгэнэ.

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Багануур дүүрэг, 1-р хороо,
. Наран хороолол, МХС ТӨХК-ийн байр, 217 тоот

АНКЕТЫН ХУГАЦАА

Зар нийтэлсэн огноо: 2019.03.14

Анкет хүлээж авах сүүлийн огноо: 2019.04.05

БҮРТГҮҮЛЭХ ИРГЭН ДАРААХ БИЧИГ БАРИМТЫГ БҮРДҮҮЛНЭ:

- Төрийн албан хаагчийн анкет
- Цээж зураг 2ш /4х6 хэмжээтэй/
- Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг болох дипломийн эх хувь, хуулбарын хамт
- Иргэний үнэмлэхний эх хувь, хуулбарын хамт
- Нийгмийн даатгалын дэвтрийн эх хувь, хуулбарын хамт
- Мэргэшүүлэх, мэргэшсэн байдлыг тодорхойлсон баримт бичиг /сертификат/ эх хувь, хуулбарын хамт
- Ажилд орохыг хүссэн өргөдөл

МЭДЭЭЛЭЛ ЛАВЛАГАА:

Сонгон шалгаруулалттай холбоотой асуудлаар 70213292, 99052306 утсаар холбогдож мэдээлэл авч болно.

ЖИЧ: Бүрдүүлэх материалын иж бүрдэл дутуу тохиолдолд хүлээн авахгүйг анхаарна уу.